

2025.04.24

№ 25/10

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн
Бичгийн Дарга томилох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Махбалын Энхзулыг ТУЗ-ийн Нарийн Бичгийн Даргаар 2025 оны 4 сарын 24-ний өдрөөс эхлэн томилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээг байгуулахыг ТУЗ-ийн дарга (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.04.24

№ 25/11

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирлын гүйцэтгэлийн үнэлгээг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Группын болон компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнг харгалзан үзэж Гүйцэтгэх захирлын жилийн ажлын гүйцэтгэлийг “Сайн” гэж дүгнэж, Нэгдүгээр хавсралтын дагуу урамшуулал олгохыг зөвшөөрсүгэй.
2. Гүйцэтгэх захирлын 2025 оны Гүйцэтгэлийн гол үзүүлэлт (KPI)-г энэ тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Энхзул), урамшууллыг тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунсүвд), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.04.24

№ 25/12

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан
санхүүгийн тайланд дүгнэлт гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл 76.1.11 дэх заалт, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “**ТУЗ**” гэх)-ийн дэргэдэх Аудитын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Грант Торнтон Аудит ХХК-аас компанийн 2024 оны санхүүгийн тайланд гаргасан аудитын дүгнэлтийг хүлээн авч, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх “Хангалттай” гэж дүгнэснийг баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулж, батлуулахыг ТУЗ-ийн дарга (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.04.24

№ 25/13

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүдийн жилийн урамшуулал олгох тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “**ТУЗ**” гэх)-ийн Цалин, Урамшууллын бодлого, ТУЗ-ийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн гишүүдийн ирц болон өөрийгөө үнэлэх үнэлгээнд үндэслэн тооцсон 2024 оны урамшууллыг Нэгдүгээр хавсралтын дагуу олгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Энхзул), Ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунсүвд), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.04.24

№ 25/14

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Урамшуулал олгох тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягт 2023 оны эхний хагас жилд Компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалд амжилттай ажилласан, 12 жилийн хугацаанд компанийг чадварлаг удирдахын зэрэгцээ хөрөнгө санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг тус тус үнэлэн Нэгдүгээр хавсралтад заасан урамшууллыг олгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Энхзул), Ерөнхий нягтлан бодогч (Б.Оюунсүвд), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ